

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР

БАТЛАВ. ДАРГА

Х.ХЭРЛЭН

Огноо: 2020.02.20

**ПРИНТЕРИЙН ХОР (ӨНГӨТ, ХАР) НИЙЛҮҮЛЭХ
ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

Төслийн нэр: Принтерийн хор (өнгөт, хар) нийлүүлэх

Харьцуулалт

**Тендер
шалгаруулалтын
код :** АМГТГ/202012003

Улаанбаатар хот
2020 он

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2020 оны 02 дүгээр сарын 26

Ашигт малтмал газрын тосны газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **“Принтерийн хор (өнгөт, хар) - АМГТГ/202012003”**-ыг нийлүүлэх үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерийг 2020 оны **03 дугаар сарын 09-ний өдрийн 15 цаг 00 минутаас** өмнө цахим системээр PDF файлаар илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Барилгачдын талбай-3, Засгийн газрын 12-р байр, Ашигт малтмал газрын тосны газар - 1 дүгээр байр, 3 дугаар давхар, хурлын танхимд **03 дугаар сарын 09-ний өдрийн 15 цаг 30 минутанд** нээнэ.

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд бусад мэдээллийг доорх хаяг, утсаар авч болно.

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Барилгачдын талбай-3, Засгийн газрын 12-р байр, Ашигт малтмал газрын тосны газар - 2 дугаар байр, 3 дугаар давхар, 318 тоот.

Утас: 99005116

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- | | |
|---|---|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ. |
| 3. Тендерийн иж бүрдэл | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
(а) Үнийн санал;
(б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
(д) Ирүүлсэн баримт бичгүүдийн товъёог /Баримт бичиг нь нүүр хуудастай, хуудсыг дугаарласан, 1 pdf файлд оруулсан байна./ |
| 4. Тогтмол үнэ | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана. |
| 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ. |
| 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна. |
| 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх | 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь ТШӨХ-д заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно. |
| 8. Гэрээ байгуулах эрх | 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас |

**олгох тухай
мэдэгдэл**

өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ul style="list-style-type: none"> - Компанийн танилцуулга - Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 оны санхүүгийн тайлан /аудитын дүгнэлтийн хамт/ - Сүүлийн 2 жилийн туршлагын мэдээлэл / нэгдсэн хүснэгтийн дагуу, гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/; - Улсын бүртгэлийн гэрчилгээ /наториатаар баталгаажуулна/ - Шүүхийн тодорхойлолт мэргэжлийн үйл ажиллагаанд алдаа гаргаж байсан эсэх /харьяалах шүүхийн тодорхойлолт / - Харилцагч банкны хугацаа хэтэрсэн зээл болон зээлийн хүүгийн өргүй тодорхойлолт - Татварын цахим тодорхойлолт - Тухайн барааны гарал үүслийн гэрчилгээ түүнтэй дүйцэхүйц бичиг баримт, тухайн барааны үйлдвэрлэгч компаний итгэмжлэл, нотлох баримт - Тухайн барааны техникийн тодорхойлолт; барааны зурагтай байх <p>Жич: Дээрх баримт бичгийн аль нэгийг ирүүлээгүй нь тендерээс татгалзах үндэслэл болно.</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж, тендерийн материалаа цахим /PDF/ хэлбэрээр ирүүлнэ. /Тендерийн материал нь нүүр хуудастай, товъёогтой, 1 pdf файлд оруулсан байна./</p> <p>Огноо: 2020 оны 03 дугаар сарын 09-ний өдөр</p> <p>Цаг: 15 цаг 00 минут</p>
ТӨӨЗ 2.2	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Барилгачдын талбай-3, Засгийн газрын 12-р байр.</p> <p>Давхар болон өрөөний дугаар: 3 давхар, 304 тоот, Хурлын танхим.</p> <p>Огноо: 2020 оны 03 дугаар сарын 09-ний өдөр</p> <p>Цаг: 15 цаг 30 минут.</p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: 1 багцтай. “Принтерийн хор /өнгөт, хар/” нийлүүлэх АМГТГ/202012003 кодтой харьцуулалтын тендер.</p>

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Барааны тодорхойлолт: Принтер, канон, плоторын дараах тоо ширхэг, марк, код, хүчин чадал бүхий; хувилах, принтерлэх үед чанарын шаардлага хангасан, цэнэглээгүй, үйлдвэрийн хор байна.

№	Хорны марк, код	Тохирох принтер, канон, плотр	Хэвлэх хуудасны тоо	Тоо	Хэмжих нэгж /ширхэг/
Хувилагчийн хор					
1	NPG-28	Canon iR2016, iR2018n, iR2318, iR2420L	9000	26	ш
2	NPG-51	Canon iR7163	8000	4	ш
3	TK-410	Kyocera KM-1650	15000	2	ш
4	AR-020T/ST/FT	Sharp AR5516 Dijital Copier	15000	2	ш
5	Хор 5325	Херох Work Centre 5325 олон үйлдэлтэй	-	4	ш
Хар хор /Lazer jet, HP, Samsung болон бусад принтер/					
6	CB436A	HP LaserJet M1120	1200	6	ш
7	CE285A	HP LaserJet Pro P1102(w), M1132mfp, M1212nf,1214nfh,1217nfw	1200	30	ш
8	Q2612A	1010,1012,1015,1018,1020(n)(nw),1022(n)(nw),3015(z),3020,3030,3050,3052,3055,M1005, M1319f	2000	25	ш
9	Q7553A	HP Laser Jet P2014(n)P2015(d)(dn)(x), M2727(nf)(nfs)	2500	10	ш
10	T-505A	HP LaserJet P2035(n), P2055(d)(dn)(x)	2200	30	ш
11	CB435A	HP LaserJet P1005, P1006, P1009	1200	10	ш
12	CF283A	HP LaserJet M125	-	20	ш
13	C4092A	HP LaserJet 1100, 3200	-	9	ш
14	CF230A	HP LaserJet MFP 227	1600	19	ш
15	CF279A	HP LaserJet M12A, MFP26A	-	20	ш
16	HP 17A	HP LaserJet M130A	-	10	ш
17	FAT-411E	Panasonic KX-MB-2030	2000	2	ш
18	Samsung 105	Samsung SCX-4623	-	5	ш
19	Samsung 101	Samsung SCX-3405	-	20	ш
20	Samsung 104	Samsung SCX-3200	2000	20	ш
Өнгөт хор /Принтер, плотр/					
21	Epson 1390	Epson Stalus Photo 1390 (6 ink cartridges,each	540	8	КОМ
22	C414,424,434,444	Epson L-1300 (4 ink cartridges,each costs)	-	5	КОМ
23	Hp 82	Hp DesignJet 800ps (6 ink cartridges, Плотр	1400, 69мл	1	КОМ
24	Hp 72	Hp DesignJet T790, T1120 (6 ink cartridges, Плотр	1400, 69мл	1	КОМ
25	Hp 78	Hp DeskJet 1280, 1180C	450, 28мл	1	

26	Нр 45		415, 28мл		КОМ
27	A0V301F Black	Konica Minolta Multifunctional & All-in-One Machines Magicolor 1690 MF	1500	1	КОМ
28	A0V306F Yellow		1500		
29	A0V30CF Magenta		1500		
30	A0V30HF Cyan		1500		

Тайлбар: Оролцогч нь дээрх бүх хорыг нийлүүлэх боломжтой аж ахуйн нэгж байна. Аль нэг принтерийн хоронд үнийн санал өгөөгүй, хороор хангах боломжгүй бол шаардлага хангахгүй тендерт тооцогдоно.

- Стандарт:** Тухайн барааны гарал үүслийн гадаадын болон Монгол улсын зохих стандартад нийцсэнийг гэрчлэх баримттай байна. Энд стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно.
- Баглаа, боодол:** Үйлдвэрийн савлагаа, баглаа боодолтой, стандартын дагуу гэрлээс хамгаалсан хар уут, доргилтоос хамгаалсан хийтэй ууттай, сайн чанарын лацтай, битүүмжлэлтэй хайрцагтай байна.
- Бараа хүргэх газар:** Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Барилгачдын талбай-3, Засгийн газрын 12-р байр, Ашигт малтмал газрын тосны газрын 1 дүгээр байранд хүргэх
- Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Хорны марк, код	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Хувилагчийн хор	NPG-28	30	ш	УБ хот, ЧД, 4-р хороо, Барилгачдын талбай-3, Засгийн газрын 12-р байр, Ашигт малтмал газрын тосны газрын 1 дүгээр байр	2020.03.18	2020.12.25	
	NPG-15	1	ш				
	TK-410	2	ш				
	AR-020T/ST/FT	2	ш				
Хар хор /Lazer jet, HP, Samsung болон бусад принтерийн хор/	Хор 5325	4	ш				
	CB436A	6	ш				
	CE285A	30	ш				
	Q2612A	25	ш				
	Q7553A	10	ш				
	T-505A	30	ш				
	CB435A	10	ш				
	CF283A	20	ш				
	C4092A	9	ш				
	CF230A	19	ш				
CF279A	20	ш					
HP 17A	10	ш					
FAT-411E	2	ш					
Samsung 105	5	ш					
Samsung 101	20	ш					

	Samsung 104	20	Ш				
Өнгөт хор /Принтер, плотрын хор/	Epson 1390	8	КОМ				
	C414,424,434, 444	5	КОМ				
	Hp 82	1	КОМ				
	Hp 72	1	КОМ				
	Hp 78	1	КОМ				
	Hp 45		КОМ				
	A0V301F Black	1	КОМ				
	A0V306F Yellow	1	КОМ				
	A0V30CF Magenta	1	КОМ				
	A0V30HF Cyan	1	КОМ				

Жич: Бараа нийлүүлэх эхний болон эцсийн хугацааны хооронд барааны захиалгыг тухай бүрд нь хийнэ .

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

Ашигт малтмал газрын тосны газрын дарга Х.Хэрлэн танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | | |
|--|-------|--|
| 1. Шалгах болон турших | 1.1. | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [моо] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан моо] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|---|
| 1. Шалгах болон турших (ГЕН – 1) | 1.1. Барааг хүлээлцэхдээ захиалагчийн тавьсан шаардлага, баглаа боодол техникийн тодорхойлолт зэргийг хангасан байдлыг харгалзан үзэж хүлээлцэх бөгөөд гологдол алдаа дутагдал илэрсэн тохиолдолд нийлүүлэгч тал үнэ төлбөргүй солих хүртэлх арга хэмжээг авна. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) | 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд: <ul style="list-style-type: none">1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;5) барааны гарал үүслийн гэрчилгээ. <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> |
| 3. Баталгаат засвар (ГЕН-5) | 5.1. Баталгаат засварын хугацаа бэлдэцийг хүлээн авсанаас хойш 1 жил байна.
Давагдашгүй хүчин зүйлсээс шалтгаалан талууд харилцан тохиролцож гэрээний хугацааг сунгаж болно. |
| 4. Төлбөр (ГЕН – 7) | 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:

Барааг нийлүүлэх гэрээг байгуулсан өдрөөс хойш хоногийн дотор нийлүүлнэ. Төлбөрийг бэлдэц акт үйлдэн баталгаажуулж, хүлээн авсанаас хойш ажлын 5 хоногийн дотор нийлүүлэгч талын нэхэмжлэлийг үндэслэн төлнө.

Барааг нийлүүлэх гэрээ байгуулсан үнээр техникийн тодорхойлолт болон бусад шаардлагын дагуу нийлүүлэх бөгөөд гэрээний үнэд тээврийн зардал, ханшийн өөрчлөлт, бүх татвар, даатгал болон бусад холбогдох зардлууд багтсан байна. |
| 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹ | 9.1. Алданги оногдуулах хувь:

Алдангийн нийт дүн:

Гэрээтэй холбоотой аливаа маргаан гарвал талууд эв зүйгээр шийдвэрлэх бөгөөд эс тохиролцвол хуулийн дагуу шийдвэрлэнэ. |
| 6. Маргааныг шийдвэрлэх | |

Гэрээний бусад зүйлсийг шалгарсан тендерт оролцогчтой гэрээ байгуулахад нэмж тусгана.

¹ Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

ЗАХИАЛАГЧ	НИЙЛҮҮЛЭГЧ
_____	_____
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
_____	_____
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
_____	_____
(Албан тушаал)	(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____ -наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг³;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

² Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

³ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]